



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 27 өдөр

Дугаар А/506

Булган сум

Үзүүлэх сургалт зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, аймгийн ИТХ-ын Хуралдааны 2021 оны IV/02 дугаар тогтоолын 4.2.1, аймгийн Засаг даргын 2023 оны А/112 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хадлан, бэлчээрийн талбайн ургацыг нэмэгдүүлэх, өвөлжөөний бууцны хөлд ногоон тэжээл тариалах зорилгоор 2023 оны 6 дугаар сарын 27-ны өдөр Гурванбулаг суман дах “Бэлчээрийг зайнаас тандан судлах суурин судалгааны төв”-д үзүүлэх сургалт зохион байгуулсугай.

2.Үзүүлэх сургалтад Рашаант, Дашинчилэн, Баяннуур, Гурванбулаг, Хишиг-Өндөр, Орхон, Сайхан, Баян-Агт, Могод, Бүрэгхангай сумдын малчид, мэргэжилтнийг оролцуулахыг холбогдох сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Арга хэмжээнд шаардагдах зардлын тооцоог хавсралтаар баталж, 4,353,000 (дөрвөн сая гурван зуун тавин гурван мянга) төгрөгийг “Бэлчээрийн менежмент” хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

4.Үзүүлэх сургалтын бэлтгэл ажлыг хангаж, үр дүнтэй зохион байгуулахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ч.Амгалан)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6323010520

Аймгийн Засаг даргын 2023 оны
06 дүгээр сарын 2-ний өдрийн А/506
тоот захирамжийн хавсралт



ҮЗҮҮЛЭХ СУРГАЛТАД ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын нэр	Тоо ширхэг	Нэгжийн үнэ /мян.төг/	Бүгд үнэ /мян.төг/
1	Тэжээлийн нэг наст ургамлын үр	1000 кг	1,500	1,500,000
2	Тэжээлийн олон наст ургамлын үр	22 кг	45,000	1,020,000
3	Тээврийн зардал /үр/	236 л	3,550	839,000
4	Сургагч багшийн зардал	2 хүн	220,000	440,000
5	Анонс	3*4	12,000	154,000
6	Гарын авлага	80	5,000	400,000
7	Оролцогчдын хоолны зардал	80	14,000	1,120,000
	Нийт зардал			4,353,000